



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 5/25

Чингис хот

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Засгийн газрын 1997 оны "Аймаг нийслэлийн Засаг даргын олгох шагналын тухай" 54 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2018 оны 318 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2003 оны А/99 дүгээр захирамжаар батлагдсан аймгийн "Хүндэт тэмдэг" олгох журам, 2015 оны А/511 дүгээр захирамжаар батлагдсан "Хан Хэнтийн алдартан тэмдэг олгох журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын хувьсгалын 99 жил, Хан Хэнтий уулын аймаг байгуулагдсаны 97 жилийн ойн баяр наадмыг тохиолдуулан аймаг орон нутгийн хөгжил цэцэглэлтэд үнэтэй хувь нэмэр оруулж, эрхэлсэн ажилдаа онцгой амжилт гаргасан нэр бүхий иргэдийг шагнасугай.

2. "Хан Хэнтийн алдартан" тэмдгээр шагнуулах хүмүүсийн нэрсийг нэгдүгээр, Засаг даргын нэрэмжит "Жуух бичиг"-ээр шагнуулах хүмүүсийн нэрсийг хоёрдугаар, зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дээрх зардалд нийт 220.000 /хоёр зуун хорин мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, буцалтгүй тусламжийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2020 оны
07 дугаар сарын 06 өдрийн 5.125
дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

Зардлын тооцоо

| № | Зардлын төрөл | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Мөнгөн дүн |
|------------|---------------------------|------------|----------------|----------------|
| 1 | Жуух бичиг | 10 | 12000 | 120.000 |
| 2 | Жуух бичиг дагалдах мөнгө | 10 | 10000 | 100.000 |
| Дүн | | | | 220.000 |